

"ХИШИГ-УУЛ" ХК-ИЙН 2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

"Хишиг-Уул" ХК ("Компани" гэх)-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж, Капитрон Банк Товер, 6 давхар, Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-ийн байр хаягт 15:00 минутад эхлэв.

Хурал даргалагч Я.Нэргүй: Компанийн ТУЗ-ийн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хурлын дагуу Компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж байна. Тооллогын комиссоос ирцийн мэдээллийг өгнө үү.

Тооллогын комисс: Компанийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 2025 оны 4 сарын 8-ны тасалбар болгосон өдрийн байдлаар Компанийн нийт гаргасан 868,252 ширхэг энгийн хувьцаанаас 64,29%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Я.Нэргүй, 16,39%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Ц.Роза, 4,18%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Г.Байгалмааг итгэмжлэлийн үндсэн дээр Я.Нэргүй төлөөлж оролцож байгаа нь энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийн нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 84,87%-г эзэмшдэг хувьцаа эзэмшигч оролцож байгаа болохыг хурал оролцогчдод мэдэгдэж байна.

Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Компанийн нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 84,87%-ийн ирцтэйгээр оролцож байгаа тул Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хүчин төгөлдөр байна.

Хурал даргалагч Я.Нэргүй хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг танилцуулж, хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлав. Хэлэлцэх асуудлын жагсаалт:

Нэг. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Хоёр. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Гурав. Компанийн 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

Дөрөв. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;

Нэгдүгээр асуудал. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Хурал даргалагч Я.Нэргүй Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг танилцуулав.

Я.Нэргүй: 2024 онд компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор борлуулалтыг өргөтөх, хэрэглэгчдийг хүнсний өргөн хэрэглээний чанартай бүтээгдэхүүнээр хангах, өргөтгөсөн болон урамшуулалт худалдаа, бэлгийн багц бэлтгэх, барааны орох хэсгийн шат, чулуун хана, шатны гишгүүр бариул зэргийг шинэчлэх, орон нутгийн телевиз, мэдээллийн байгууллагатай гэрээбайгуулан зар сурталчилгаа тогтмол явуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн байна. Мөн ажилчдын нийгмийн бодлого, боловсролд чиглүүлэн эрүүлжүүлэх, бясалгалын хичээлд хамруулж, эрүүл мэндийн дасгал сургууль зохион байгуулж, шаардлагатай мэргэжлийн сургалтад хоёр хүн

хамруулсан байна. Түүнчлэн 2024 онд 8 хүний ажлын байр нэмэгджээ. Дэлгэрэнгүй тайланг тарааж өгсөн дүгнэлтэд бичсэн байгаа.

Ц.Роза: ТУЗ-ийн баталсан дүгнэлтэд зарим өөрчлөлтийг оруулж, батлах саналтай байна. Тухайлбал, гүн хөлдөөх камер суурилуулах ажил бүрэн гүйцэтгэгдээгүй байгаа тул 50 хувьтай гүйцэтгэгдсэн гэж засварлах, тандир зууханд мах шарж, утах шинэ үйлчилгээг бүрэн нэвтрүүлсэн байгаа тул 100 хувьтай гүйцэтгэсэн гэж засварлах, шаардлагатай мэргэжлийн сургалтад нийт 4 биш 2 хүн хамруулсан тул үүнийг 2 болгож засварлах, 2024 онд албан хаагчдын хүүхдүүдэд сургалтын төлбөрийн хөнгөлөлт, бусад хандив үзүүлээгүй тул үүнийг хасах шаардлагатай гэж үзэж байна.

С.Нэргүй: ТУЗ-ийн дүгнэлтэд өөрчлөлт оруулан батлах саналыг хүлээн зөвшөөрч байна. Дараагийн хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Хоёрдугаар асуудал: Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах

Хурал даргалагч Я.Нэргүй Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг танилцуулав.

Я.Нэргүй: 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, холбогдох ТУЗ-ийн дүгнэлт, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг тараан өгсөн байгаа. Дүгнэлтэд дурдсанаар 2024 онд борлуулалтын орлого 1,504,363,621 төгрөг болсон ба үүнээс татварын дараах 69,390,586 төгрөгийн ашигтай ажилласан. Борлуулалтын орлого нь он, онд харилцан адилгүй байгаа нь тухайн үеийн иргэдийн худалдан авах чадвар, нөхцөл байдлаас шалтгаалсан гэж үзэж байна. Тус дүгнэлтийг батлахтай холбоотой аливаа санал байна уу?

Ц.Роза: Дүгнэлттэй холбоотой санал байхгүй тул батлахыг дэмжиж байна.

Я.Нэргүй: Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлахыг дэмжиж байгаа гэж үзээд дараагийн асуудалд орцгооё.

Гуравдугаар асуудал: Компанийн 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах.

Я.Нэргүй: 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулав. Үүнтэй холбоотой зарим нэг зүйлсийг нэмэх, хасах, өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Тодруулбал, 1900 м.кв талбайд дотор засал чимэглэлийн ажил гүйцэтгэхээр байгаа нь 2025 онд гүйцэтгэхэд хэтэрхий өндөр тоо байх тул үүнийг 434 м.кв болгон багасгах, төлөвлөгөөнд Багануур дүүргийн ЗДТГ-тай хамтран шинээр ажлын байр нэмэгдүүлэх ажлыг нэмж оруулах, дүүрэг болон нийгэм, иргэдэд чиглэсэн ажлуудыг Д.Энхтүвшинд даалгасан байгааг Ц.Роза, О.Нямхүү, Н.Сүлд-Оргил нарт даалгах саналтай бана.

Ц.Роза: Өөрчлөлтүүдийг оруулан 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг дэмжиж байна.

Дөрөвдүгээр асуудал: ТУЗ-н гишүүдийг томилох.

Хурлын дарга Я.Нэргүй: Мэдэж байгаачлэн 2024 оны 11 сарын 22-ны өдөр нээлттэй дуудлага худалдаагаар миний бие 608,400,000 төгрөгөөр Компанийн нийт 34 хувийн хувьцааг худалдан авахаар шалгарч, улмаар нийслэл Компанийн хувьцаа эзэмшигч байхаа больсон. Иймээс Нийслэлийн Өмчийн Харилцааны Газрын саналаар томилогдсон ТУЗ-ийн гишүүд болох С.Даваасүрэн, С.Сэржжаргал нарыг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, оронд нь Н.Цэцэнхаан, Н.Сүндэрьяа нарыг шинээр ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгох саналтай байна. Түүнчлэн ТУЗ-ийн гишүүн Ж.Ганболд гадаад явж буйтай холбогдуулан Д.Энхбаяр гишүүнийг хараат бус гишүүнээр томилох, Ж.Ганболд гишүүнийг ердийн гишүүнээр томилох саналтай байна

Ц.Роза: Д.Энхбаяр гишүүнийг хараат бус гишүүний шаардлагыг хангаж байгаа юу?

Я.Нэргүй: Компанийн тухай хуульд заасан бүх шаардлагаа хангаж байгаа, засаглалын сургалтад суусан гэрчилгээг мөн харж болно.

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь хэсэгт заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээний хүрээнд ТУЗ-н гишүүдийг сонгох эрхтэй байх тул ТУЗ-н хурлаас дэвшүүлсэн нэр дэвшигч гишүүдийг ТУЗ-н гишүүдээр томилох саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар дэмжин томилов.

Хурал даргалагч Я.Нэргүй: Хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дараах асуудлыг шийдвэрлэлээ.

ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
3. Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөөг баталж, цаашид төлөвлөгөөний дагуу Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг тусалцааг үзүүлэн ажилласугай.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд доор дурдсан нэр бүхий гишүүдийг сонгож, томилсугай. Үүнд:

Ердийн гишүүд:

1. Я.Нэргүй
2. Ц.Роза
3. Н.Цэцэнхаан
4. Н.Сүндэрьяа
5. Н.Сүлд-Оргил
6. Ж.Ганболд

Хараат бус гишүүд:

1. Д.Гонгор

2. Д.Сэржамц
3. Д.Энхбаяр

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлж, мэдэгдэхийг Хуульч А.Солонго, Э.Анударь нарт даалгасугай.

Дээрх асуудлыг хэлэлцэж, санал хураалт явуулж дууссаны дараагаар Хурал даргалагч Я.Нэргүй хурал хаасныг мэдэгдэв. Хурал 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 15:55 цагт хаав.

ХУРЛЫН ДАРГА:



Я.НЭРГҮЙ